



LEGAL NEWSLETTER

2025 May №56

AKP Law Firm

Бид энэ оны 5 дугаар сард батлагдсан эсхүл хүчин төгөлдөр болсон хууль, Засгийн Газрын тогтоол, Сайдын тушаал зэргээс заримыг нь онцлон танилцуулж байна.

I. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1.1. ТЭРБУМ МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР

§ Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх нь 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр ийнхүү зарлиг буулгав.

1. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.

2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.

Ийнхүү өнгөрөгч 5 дугаар сард мод тарих өдрүүд тохиосон билээ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2021 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар эхлүүлсэн бөгөөд 2030 он хүртэл нийт 1 тэрбум мод тарьж ургуулах зорилт тавьсан. Энэ хүрээнд төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоо эрчимжиж, 2024 оны байдлаар нийт 250 сая гаруй модны суулгац тарьсан байна.

II. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2.1. АГААРЫН ТЭЭВРИЙГ ХЯЛБАРШУУЛАХ ЖУРАМ

§ Зам, тээврийн яамнаас агаарын хөлөг, багийн гишүүд, зорчигч, ачаа, шуудан, бараа болон бусад эд зүйлсийг улсын хилээр хүндрэлгүй, саадгүй нэвтрүүлж, хилийн хяналт шалгалтын үйл

ажиллагааг давхардалгүй, шуурхай зохион байгуулах, холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор “Агаарын тээврийг хялбаршуулах журам”-г шинэчлэн Засгийн газрын 168 дугаар тогтоолын хавсралтаар батлав.

Энэхүү журам нь олон улсын жишигт нийцсэн агаарын тээврийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг түргэн шуурхай болгох, хүнд суртлыг багасгах, цахим шийдлүүдийг нэвтрүүлэхэд чиглэж байгаа юм. Журамд:

- Нислэгийн өмнөх болон дараах шалгалт, бүрдүүлэлтийн хугацааг багасгах,
- Ачаа тээшний хяналтын процессыг цахимжуулах,
- Агаарын тээврийн оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах,
- Олон улсын ICAO, IATA-ийн зөвлөмжийг тусгах зэрэг заалтууд багтжээ.

Тус журмын хэрэгжилтийн хүрээнд 5 дугаар сараас шинэ чиптэй гадаад паспортыг иргэдэд тарааж эхэлсэн бөгөөд чиптэй гадаад паспорттой иргэд Чингис Хаан нисэх буудал дахь хилийн цахим гарц (Automated Border Control Gates буюу E-Gate)-аар очер дараалалгүй, хялбар, шуурхай нэвтрэх боломжтой болсон байна.



Мөн цаашид ч шинэ журмыг хэрэгжүүлснээр зорчигч, ачаа тээвэрлэгчдэд үүсдэг саатал, хүлээлт буурч, Монголын агаарын тээвэр илүү өрсөлдөх чадвартай болох хүлээлттэй байна.

III. САЙДЫН НАРЫН ТУШААЛ

3.1. АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд нар тус тус харьяалах салбартаа албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагуудыг баталжээ. Эдгээр шаардлагуудыг дэлгэрэнгүй үзэхийг хүсвэл доорх холбоосуудын харгалзах холбоосоор нэвтэрч, хавсралт хэсэгт дарж үзнэ үү.

- **Боловсролын сайдын А/189 дугаар тушаал**
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1743134522336>
2



- **Эрүүл мэндийн сайдын А/189 дугаар тушаал**
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1743139159523>
2



- **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын А/175 дугаар тушаал**

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1743139129247>
2



- **Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын А/79 дугаар тушаал**
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1743139147780>
2



- **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 105 дугаар тушаал**
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1743162137777>
2



3.2. МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИЙН ЭРХ ОЛГОХ БОЛОН ЭРХ СУНГАХ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Монгол Улсын Сангийн сайд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 17.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн “Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох болон эрх сунгах шалгалтыг зохион байгуулах журам”-г шинэчлэн баталжээ.

Тус журам нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох болон эрх сунгах шалгалтыг зохион байгуулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагын шалгалтад тэнцсэн иргэнд Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой бөгөөд дэлгэрэнгүй үзэхийг хүсвэл доорх холбоосоор нэвтэрч, хавсралт хэсэгт дарж үзнэ үү.

- **Монгол Улсын Сангийн сайдын А/95 дугаар тушаал**

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1743172343994>

[2](#)



Дээрх агуулгатай холбоотой бусад дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл доорх хаягаар холбогдоно уу.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
3-р хороо, Жуулчны гудамж, Pearl tower А блок
902 тоот

Web: www.akp.mn

E-mail: contact@akp.mn

Tel: 7704-1414